

## БЭЛГЭДЛИЙН ОРЧИН ҮЕ, ИРГЭНШИЛ, ШАГНАЛ, ХУУРМАГ ЭЛИТ

М. Ууганбаяр \*

Түрэгийн нэрт сэтгэгч, зохиолч, философич Х.Явүз Түрэгийн орчин үежилтийг(modernization) тэмдэг судлалын үүднээс судлаад Түрэг улсад орчин үежилт тодорхой ойлголтонд бус бэлгэдэлд үндэслэсэн нь түрэгийн орчин үежилтийн хямралын гол шалтгаан болж байна хэмээн үзэхдээ энэ нь Европын иргэншлийн арван наймдугаар зууны соён гэгээрлийн дараачаас түгэж тархсан хүний эрх, ардчилал, ялгарал, иргэний нийгэм гэх ойлголтууд төдийгүй эртний Грек Ромоос гаралтай логос хэмээх ойлголтыг өөрчилсөн соён гэгээрлийн оюун ухааныг ч өөриймшүүлж чадаагүйтэй холбоотой гэдгийг, өөрөөр хэлбэл түрэгүүд нэг талаараа Францын соён гэгээрлийн Вольтэр Дидро нарын шүүмжлэлт эргэлзэгч оюун ухааныг бус Робеспьерийн догматик якобинч оюун ухааныг өөриймшүүлсэн нь угтаа бэлгэдлийн сэтгэлгээг л бий болгосон гэх санааг илэрхийлсэн байдаг. Х.Явүз “Түрэгийн орчин үежилт европын иргэншлийг мэдлэг болгож хувиргах, Альтюссэрийн хэлдгээр сэтгэхүйн боджилт *concret-de-pensée* болгон өөрчлөх боломж байхгүй байгаатай холбоотой. Өнөөдрийн орчин үежилтийн хямралын уг шалтгааныг ойлголтын ор зайг бэлгэдлүүд дүүргэсэн явдал бүрдүүлж байна. Байгаль хоосон зайг үзэн яддагтай адил соёл ч хоосныг үзэн яддаг. Латинчуудын *homo homo* гэдэгчлэн байгаль соёл аль аль нь хоосон зайг заавал дүүргэдэг. Бэлгэдлүүд Европын суурь үндсэн ойлголтуудыг орлох болсон нь бидэнд бэлгэдлийг иргэншил гэж үзэх, иргэншлийг ойлголтоор бус бэлгэдлээр байгуулж буй гэж бодоход хүргэж байна” гэж бичжээ.

Профессор Шэриф Мардин Түрэгийн орчин үежилтэнд Намык Кэмалийн “Интибах” романыг өгүүлэхдээ энэхүү романы гол баатар Али Бэйд ээж нь чөлөөт цагаа өнгөрөөхийн тулд европ маягаар хүмүүжсэн алафранга шивэгчин олж өгөх болсноо хэлсэнд Али Бэй дургүйцэн бүсгүйг үзэн ядах бөгөөд энэ нь Али Бэй өөр бүсгүйд хайртай болсноос тэр ажээ. Шэриф Мардиныхаар эл сэдэв Али Бэй шивэгчний тогтолцоо байгууламжид таагүй хандаж буйн илэрхийлэл болох бол, Х.Явүзийнхаар романы энэхүү үйл хөдлөл санаа нь бэлгэдэл ойлголтыг орлосны тухай гайхалтай жишээ юм. Энд нэг талаас эмэгтэйчүүдийн эрх чөлөөг хаан боох шивэгчний институт, байгууламжийн бүтэц нөгөө талаас алафрангажих ёс Намык Кэмаль “Интибах” романы гол баатар Али Бэйг шивэгчний байгууламжийг эсэргүүцэж буй хэмээн үзүүлж буй боловч тэрбээр Европ маягаар хүмүүжсэн алафранга шивэгчинд зөвхөн өөр нэг эмэгтэйд хайртай болсон учраас л үгүйсгэж эсэргүүцэж байна. Энд бэлгэдэл болохын

\* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Хэл шинжлэлийн тэнхим

хувьд Европ маягаар хүмүүжих буюу алафрангажих ёс эмэгтэйчүүдийн эрх чөлөө гэх ойлголтыг орлож буй ба энэхүү ойлголт хоосон зай болж, эл хоосонг бэлгэдэл дүүргэж байна. Ролан Бартын тэмдгийн эзэнт улс гэх үгийг бага зэрэг өөрчилж өгүүлэхэд ойлголтын засаглал бус бэлгэдлийн эзэнт улс хүчин төгөлдөр оршиж байгаа ажээ. Түрэгийн орчин үежилт ч иймэрхүү бөгөөд Бүгд найрамдах улсын орчин үежүүлэгч нар ч европын иргэншлийг хүний эрх гэх мэт ойлголтоор бус малгай үсэг гэх мэт бэлгэдлүүд (Хилми Явүз Бүгд найрамдах улсын эхэн үед түрэгийн шинэчлэгчид малгайны хууль латин үсэгт шилжих хууль гарган мөрдүүлж байсныг дурдаж байна М. У.) энд төлөөлсөн болох ажээ.

Х.Явүз “Түрэг орчин үежилтийн тэмдгийн судалгаа түрэг орчин үежилт буюу өрнөжилтийн метонимик өрнөжилт гэдгийг харуулж байна. Метоним гэдэг нь хэсэг бүхэлтэй байраа сольж бүхлээ орлоно гэсэн утгатай. Төгөлдөр хуур тоглох, малгай өмсөх, францаар ярих нь өрнөжихийн нэг хэсэг болж болох боловч европжихийг бүхэлд нь төлөөлөхгүй европжихийг зөвхөн ойлголтын түвшинд төлөөлүүлж болно. Энэ нь европжилт иргэншил болдогтой холбоотой. Аливаа иргэншил зөвхөн өөртөө хамаарах ойлголтоор л илэрч болно. Өрнийн иргэншил төгөлдөр хуур тоглох малгай өмсөх эсхүл францаар ярихаар бус соёлын хүрээнд шинжлэх ухаан, философи, улс төрийн хүрээнд ардчилал, хүний эрх, иргэний нийгэм гэх ойлголтоор илрэх ёстой. Түрэгийн орчин үежилт, өрнөжилтийг бодит харагдах бэлгэдлээр хүлээж авдаг учир хэсгийг бүхэл гэж эндүүрсэн ба аливаа иргэншлийг идээшүүлэх нь хийсвэр ойлголтоор л боломжтойг анзаарч ялгаж чадсангүй. Амьдрах хэв маяг аливаа иргэншлийн чухал шинжийн нэг боловч иргэншлийг хэзээ ч зөвхөн амьдрах хэв маяг гэж үзэж болохгүй. Амьдрах хэв маяг бол иргэншлийн нэг хэсэг боловч иргэншилтэй адил тэнцүү зүйл биш” хэмээн бичиж байна.

Х Явүз, Османы Танзимат болон Сэрвэт-и фюнүний үеийн романд гарах өрнөжсөн орчин үеийн эмэгтэйчүүдийн дүр бүгдээрээ төгөлдөр хуур тоглож, бүх эрэгтэй баатрууд франц хэл сурах сонирхолтой байдгийн шалтгааныг судлаад, төгөлдөр хуур франц хэл гэсэн хоёр бэлгэдэл Османчууд Танзиматтай цуг эхэлсэн өрнөжиж орчин үежих үйл явцын хэрхэн хүлээж авсныг харуулах ба төгөлдөр хуур тоглох францаар ярих товчдоо европ хүн лүгээ адилаар хувцаслаж европчуудын амьдралын хэв маягийг дуурайх нь Османчуудын хувьд орчин үежих гэсэн үг бөгөөд европжихийн бэлгэдлийн тэмдэглэгээ байжээ.

Танзиматын үеийн түрэгийн зохиолч А.Митхад Эфэндийн “Юсс- и Инкилабы” зохиолд орчин үежилт өрнөжихийн тухайд османы сэтгэлгээний бүтцийн деконструкцийг харуулсан гэдгийг тэмдэглээд иргэншлийн төслийг Османы удирдагч анги метонимик хэлбэрээр хүлээн авч мэдэрч байсныг А.Митхад Эфэнди жишээлэн харуулжээ. А.Митхад Эфэнди Абдүл Азизийн үед цэргийн дүрэмт хувцсыг өөрчилж эхэлсэн шинэчлэлийг бодит хэсгийн төсөл болохын хувьд дэмжсэн хэдий ч хийсвэр ерөнхий төсөл болох орчин үежилт европжилтийг зөвхөн цэргийн хувцасны өөрчлөлт гэж үзэхийг зөвшөөрөөгүй байна. А.Митхад Эфэнди “Низа-ы Илм юд Дин” хэмээх бүтээлдээ иргэншлийг хувцас хунараас хайж хэрэггүй хэмээжээ. Өөрөөр хэлбэл, А.Митхад Эфэнди иргэншлийн бодит бэлгэдэл, хийсвэр ойлголтын ялгааг ойлгож байна. Францаар ярих нь Танзиматын сэхээтнүүдийн хувьд орчин үежилтийн хэсэг бус орчин үежилт өөрөө юм. Танзиматчуудын хувьд франц хэл, хэл бус дээд зиндааны таньж ойлгохуй, ангид тусгаар эргэцүүлэн бодохуй бөлгөө. Товчхондоо, франц хэл Османыг басамжлан доршоож буй иргэншил ажээ. Жэмил Мэричийн тэмдэглэснээр,

Мидхат Паша Жэвдэт Пашад “Чи франц хэл мэдэхгүй учраас чиний ухаан хүрэхгүй” гэж хэлдэг байжээ. Мидхат Пашагийнхаар франц хэл ойлгож ухаарахуйн дээд тэмдэг бөгөөд зөвхөн франц хэл мэддэг хүн өрнийн иргэншилтэй холбоотой асуудлыг ойлгох аж. Мидхат Паша мэтийн Өрнийг шүтэн бишрэгчид төдийгүй Танзиматын агуу их консерватив үзэлт жанжин А Жэвдэт Паша хүртэл түүний охин Фатма Алийэ Ханум франц хэл сурч роман орчуулснаас хойш охиноо эцгийн хайр энэрэлээр бус хүндэтгэн харж хандаж эхэлснийг мөн л Жэмил Мэрич бичжээ. Танзиматын дээд түшмэл ангийнхан өрнийг шуудханаар даган баясч шүтэн биширч байсан бол А.Митхад Эфэнди франц хэлийг зөвхөн хэл гэж үзээд франц хэлийг дээд зиндааны ухааран мэдэхүй анги тусгаар эргэцүүлэн бодохуй, Османыг доршоон басах иргэншил гэж тооцохыг эсэргүүцэж байв.

Мидхат Паша Өрнийн иргэншлийг франц хэлтэй адилгаж байснаараа метонимик сэтгэлгээг харуулж байхад А.Митхад Эфэнди энэхүү хялбаршуулан буулгалт нь сэтгэлгээний томоохон алдаа болсныг ухаарч байжээ.

А.Митхад Эфэндийн бичсэнээс харахад, Абдул Азизийн үед нээгдсэн Галатасарай Сүлтани гэх сургууль Османы сургууль гэхээсээ Франц сургууль болоход ихэд ойрхон байжээ. А.Митхад Эфэнди, эл сургуульд Османы түүхийн хичээл дээр нэгэн багш Османчуудыг зэрлэгүүд гэж нотолж байсныг онцлон дурджээ. Энэ нотолгоо дүгнэлт франц хэлийг Османыг доромжлон гутаах иргэншлийн сэтгэлгээний үр дүн болохыг харуулж байна. Энэхүү сэтгэлгээ Танзиматаас эхлээд Түрэгийн орчин үежилтийг угтаа ориентализм болохыг тайлбарлан тодруулж байна.

Хилми Явүзийн үзэж байгаагаар, орчин үежилтийг статусын бэлгэдэл гэж ойлгох нь Бүгд Найрамдах Улсын үед ч үргэлжилж Османы Танзимат Сэрвэт-и фюнүний үетэй харьцуулахад статусын бэлгэдэл олширсон байна. Танзимат Сэрвэт-и фюнүний үед уран зохиолын эр эм дүр баатрууд нэг л статусын бэлгэдэлийг эзэмшиж эрэгтэйчүүдийн хувьд францаар ярих тэргүүтнээр илэрч байсан бол орчин үеийн Бүгд Найрамдах Түрэг улсын үед статусын бэлгэдлийн тоо хязгааргүй нэмэгдсэн. Одоо зөвхөн төгөлдөр хуур тоглож францаар ярих бус түүнчлэн франц хэлний орыг статусын бэлгэдэл болох англи хэл эзэлсэн (Монголын нийгмийн тухайд орос, англи хэл гэж өөрчлөн ойлгож болно М. У.) орчин үеийн амьдралын хэвмаягийн хүрээ орон ихээхэн нэмэгдсэнээр статусын бэлгэдэл нэмэгдэхэд хүрсэн статусын бэлгэдэл нэгээс олон болж хувирсан нь орчин үежилтийн метонимик бүтцийг өөрчилсөнгүй бөгөөд эдгээр бэлгэдлийг бүгдийг нь хамж нэг бүлэг үүсгэлээ ч үргэлж шинэ статусын объект үүсгэж статусын объектээ өөрчилж буй хэрэглээний нийгэмд бүрэн бүтэн бүлэг гэж ярих боломжгүй билээ. Орчин үежилт ба статусын объектийн хоорондын харьцаа имманэнт харьцаа бус бөгөөд орчин үежилт статусын объект гэж үзэх трансцэндэнт бүтэц болно. Ийнхүү орчин үежилтийг статусын бэлгэдэл гэж үзэгчид европын буюу орчин үеийн, өрнийн хүмүүс болох битгий хэл европ, өрнө орчин үеийг ямар утгатайг ч үл ухаарч байгаа ажээ. Орчин үежилт, өрнөжилт, түрэгийн нийгэмд метонимик бэлгэдлийн сэтгэлгээ болсон өөрөөр хэлбэл, бүхлийн оронд гарч ирсэн хэсэг нь бүхлийг төлөөлөх болжээ. Бид дээр өгүүлсэн бүхнийг Монголын нийгэм, орчин үетэй угтаа адил байгаагаас монголын орчин үеийг бэлгэдлийн орчин үе хэмээн нэрлэж байна.

Италийн нэрт социологич Вильфредо Парето элитийн онолдоо элитийг нэлээдгүй өргөн утгаар тайлбарласан бөгөөд үйл ажиллагааныхаа салбарын хамгийн дээд үнэлгээг авсан хүмүүсийн бүлгийг элит гэж нэрлэсэн ба Раймон Ароны тайлбарлан бичсэнээр

Парето мэргэжлийн зиндаачлалын хамгийн дээд оргилд гарсан үйл ажиллагааныхаа хүрээ бүрт амжилт олж зорилгодоо хүрсэн цөөн тооны хувь хүмүүсийг элит гэж хэлж байгаа ба амжилт олсон худалдаачин, амжилт олсон жүжигчин, амжилт олсон демимондэн (хээнцэрлэгч дээд зиндааны бүсгүй гэсэн утгатай үг М. У.) амжилт олсон улс төрч амжилтад хүрсэн профессор бүгдээрээ элитэд хамаарна гэж үздэг билээ (Арон 27)

Элитийг ийнхүү өргөнөөр авч тодорхойлох нь саармаг үнэлэмжийн утгатай ба эрх мэдэл, эд баялаг, мэдлэг гэх мэт зүйлсийн нийгмийн үнэлэмжийн хэмжээсийн хамгийн дээд шат давхаргыг хамаарах юм. Парето элит гэх нэр томъёог шашин (хамгийн ариун), урлаг (хамгийн уран сайхан), ёс суртахуун (хамгийн сайн явдалт буянлаг) тийш өргөжүүлж үзэхэд ч бэлэн байжээ.

Паретогийнхаар, нийгмийг голдуу шилмэл цөөнх хамгийн хүчирхэг эрчтэй чадварлаг хүмүүс удирддаг билээ. Парето түүхийг элитийн хөдөлгөөн сэлгээ (circulation of elite) гэж үзсэн ба хуучин элитийг шинэ элит халах маягаар тойрог хүрээгээр элит хөдөлж сэлгэж байдаг.

Паретогийн санааг дэлгэрүүлэн бодоход, Монголын улс төржсөн хуурмаг элитийг тодруулдаг шагнал нь элитийн сэлгээ шилжилтийг гацааж, элитийг мөхөөх хэрэгсэл болжээ.

Монголын шагналаар тодорсон элитийг иргэншсэн, ардчилсан, жинхэнэ элит бус улс төржсөн төрөөс хараат, тоталитар, авторитар, хуурмаг элит гэж нэрлэж болох юм.

Социологийн нэр хүнд статус гэсэх ойлголтыг тооцон үзэхэд монголын нийгэмд нэр хүндийг статус эзлэн авч нэр хүнд гэх ойлголтыг статус гэх ойлголт үгүй хийсэн тул монголын элит ангийг нэр хүнд бус статус тодорхойлох болжээ.

Хувь хүний нийгэмд олж авсан байр суурийг статус гэх бол нэг талаас тухайн статусын үнэлгээг нэр хүнд (prestige) гэдэг бөгөөд монголын нийгэмд хувь хүний төс дүр нэр хүнд хүндлэлийг статусаас салгаж бодохгүйгээр барахгүй статус бүхэлдээ нэр хүндийг орлож байна.

Цаашлаад статус нь бэлгэдэл болжээ. Монголчууд элитийг зөвхөн статусын бэлгэдэлтэй адилтгадаг бөгөөд монгол хүн чинээлэг байхыг томоохон шилтгээнд амьдрах, эрдэмтэн болохыг цол хэргэм зүүх гэдгээр төсөөлөн боддог нь монголчууд иргэншил, орчин үежилтийг ойлголтоор бус төс дүр, бэлгэдлээр бүтээж байгаатай холбоотой юм. Ийнхүү статусын бэлгэдэл нь элитүүдийг илэрхийлэх болсны тод жишээ нь шагнал бөлгөө.

Энэ бүхнээс харвал монголын бэлгэдэлжсэн элит бол хуурмаг элит мөн. Өөрөөр хэлбэл шагналыг монгол маягийн символизм, улмаар монголын орчин үежилтийг Х.Явүзийн түрэгийн орчин үеийг бэлгэдлийн орчин үе хэмээн нэрлэсэнтэй адилаар бэлгэдлийн орчин үе гэж нотолж болох юм. Философийн талаас авч үзвэл, монголын орчин үежилтийн сэтгэлгээ, бодит байдал (reality) төс дүр (image) гэсэн хоёр өөр ахуйн хүрээг ялгахгүй байгаа төдийгүй иргэншилд оюун ухаанаар бус төсөөллөөр хандаж байгаа маань биднийг үнэн рүү бус харин төөрөгдөл рүү залж хөтөлж байгаа хэмээж болно.

Х.Явүз, Готтлоб Фрегегийн Ueber Sinn und Bedeutung (Утга ба илгээмж) хэмээх бүтээлдээ аливаа тэмдгийн утга (sense) хийгээд зааж буй илгээмж (reference) нь тухайн тэмдгийн санаанаас (idea) ялгаатай болохыг бичсэнийг дурдсан ба мод хэмээх тэмдгийн утга хийгээд илгээмж буюу зааж буй объект тухайн тэмдгийн бидний сэтгэлгээнд буй санаанаас тусдаа болох ажээ. Миний хувьд нүдээ аньж модыг төсөөлөх нөхцөлд хүн

бүрийн сэтгэхүйд багтах модны тухай санаа буюу төс дүр бие биенээсээ ялгаатай байх болно. Фрегегийн зааснаар бид бүхэн модны утгыг адилаар бодох бол модны санааны хувьд, зарим хүн царс модыг, зарим хүн улиас, ороонго дэнс, уд мод, гацуур гэх мэтчилэн өөр өөр модыг төсөөлнө. Лейбницийн Si duo idem faciunt, nkn est idem гэх алдарт томъёоллоор хоёр өөр хүн нэг объектийг төсөөлөхөд тухайн хоёр хүний сэтгэхүйд өөр өөр санаа илэрнэ.

Хилми Явүз түрэгүүдийг тэмдэг буюу үгийг үгийн утга болох ойлголтоор бус сэтгэхүйдээ байгаа санаагаар тодорхойлдог тул иргэний нийгэм олон нийтийн орон зай бэлгэдэл гэх мэт үгсийн утга, ойлголт болохын хувьд тодорхойлолтоос (definition) бус харин сэтгэхүйд оршиж байгаа санааны дүрслэлтээс (description) шалтгаалах болж байна. Мод гэж хэлэх нөхцөлд хүн бүрийн сэтгэхүйд өөр өөр модыг төсөөлөх нь харилцахуйг боломжгүй болгоно.

Сэтгэхүйдээ модын царс гэж төсөөлөх хүн модны гол бүдүүн гэж хэлэх бол модыг улиас гэж төсөөлөх өөр нэг хүн модны гол нарийн гэж хэлэх болно. Модыг царс гэсэн санаагаар төсөөлөх хүн модны навчийг хүний гартай адил гэх бол гацуурыг төсөөлөх хүн огт өөрөөр бодно.

Х Явүзийн үзэж байгаагаар, түрэгчүүд митос буюу домгийн сэтгэлгээнээс логосийн сэтгэлгээ рүү шилжээгүй учраас Фрэгэгийнхээр бол санаагаар, өөрөөр хэлбэл, бэлгэдлээр сэтгэж байна. Бодох сэтгэх (to think) төсөөлөх (to imagine) хоёр адилсах нь орчин үежилтийг сэтгэлгээний хувьд өөриймшүүлээгүйн жишээ болох ба орчин үежилт гэж хувцас хунарыг бус сэтгэлгээний өөрчлөлтийг хэлнэ.

## НОМ ЗҮЙ

Aron, Raymond, Les étapes de la pensée sociologique: Montesquieu, Comte, Marx, Tocqueville,  
Durkheim, Pareto, Weber Paris: Gallimard, 1967  
Yavuz Hilmi *Modernleşme: Parça mı, Bütün mü? Batılılaşma: Simge mi, Kavram mı?*  
Modern Türkiye'de Siyasi Düşünce: 3, İletişim Yayınları, 2002  
Yavuz Hilmi Yazın, Dil, Sanat, Boyut Kitapları, İstanbul. 1996  
Yavuz, Hilmi Kara Güneş, Can Yayınları 2. Basım, İstanbul.2003  
Yavuz Hilmi Alafrangalığın Tarihi Geleneğin Tasfiyesi ya da Yeniden Üretilmesi [Timaş Yayınları](#) / [Deneme Dizisi](#) Istanbul 2009

## SUMMARY

Symbolized modernity, civilization, prize and pseudo-elites

Generally on the basis of the thoughts of Hilmi Yavuz on Ottoman and Turkish modernization process and metonymic or symbolic mind and Pareto's elite theory the author analyses Mongolian prize system as a way of creating Mongolian elites and expresses his points of view on Mongolian modernization and Mongolian symbolized pseudo-elites.